

“ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ийн 2014 оны жилийн

28

үйл ажиллагааны тайлан

Нэр: “Жуулчин говь” ХК

Хаяг: Өмнөговь аймаг , Ханхонгор сум

Утас: 91935355, 96658704

Улсын бүртгэлийн мэдээлэл: Улсын бүртгэлийн №1110001007, регистер №2016273

“Жуулчин говь” ХК нь “Жуулчин говь-1”, “Жуулчин Хонгор” гэсэн жуулчны баазуудтай улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байна.

“Жуулчин говь-1” бааз нь анх 1963 онд байгуулагдсан. Байгуулагдсан цагаасаа хойш өнөөг хүртэл Монгол Улсын аялал жуулчлалын салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж байна. 2000 онд Хонгорын голын дэргэд “Жуулчин Хонгор” жуулчны баазыг шинээр байгуулан өргөтгөл хийж ашиглалтанд оруулсан.

“Жуулчин говь-1” жуулчны бааз нь Улаанбаатар хотоос 560км, Даланзадгад хотоос 35км, “Говь гурван сайхан” байгалийн цогцолборт газарт байрладаг. Нэг ээлжиндээ 100-120 хүн хүлээн авах гэр буудалтай, 90 хүнд зэрэг үйлчлэх тохилог ресторантай , 24 цагийн турш ажиллах халуун, хүйтэн устай душтэй, боловсон бие засах газартай.

“Жуулчин Хонгор” жуулчны бааз нь Баянхонгор аймгаас 420км, Өвөрхангай аймгаас 390км, Өмнөговь аймгийн төвөөс 230-км-т үзэсгэлэнт Хонгорын элсний хажууд байгалийн үзэсгэлэнт газарт байрладаг. Нэг ээлжиндээ 70 хүн хүлээн авах гэр буудалтай, 50 хүнд зэрэг үйлчлэх тохилог ресторантай, 24 цагийн турш ажиллах халуун хүйтэн устай душ, боловсон бие засах газартай , сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан байгаль орчинд ээлтэй жуулчны бааз юм.

“Жуулчин говь” ХК нь 2014 оны 4-р сарын 29-ны өдрөөс жуулчин хүлээн авах бэлтгэл ажилдаа орж улмаар 5-р сарын 08-ны өдрөөс эхний жуулчидаа хүлээн авч үйл ажиллагаагаа эхлүүлэн 2014 оны 10-р сарын 06-ны өдөр хүртэл Гадаад дотоодын жуулчид болон гэрээт компаниудадаа үйлчиллээ.

Тайлант жилд байнгын ажлын байрны 8, гэрээт 20гаруй ажиллагсадтай ажилласан байна.

Үүнд: 1. Захирал ----- 1

2. Менежер ----- 1
3. Нярав ----- 2
4. Тогооч ----- 2
- 5 Манаач ----- 2
6. Жолооч ----- 1

25

Тайлант онд давхардсан тоогоор гадаадын 1014, дотоодын 613 , нийт 1627 амрагч жуулчин хүлээн авлаа.

Компани санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар , нийгмийн даатгал болон бусад татварын тооцоог цаг хугацаанд нь гаргаж , татвар , нийгмийн даатгалын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

Тайлант онд нийт 129,623.688 төгрөгийн орлоготой ажилласнаас доорхи зардлууд гарсан болно.

д/д	Гүйлгээний утга	Зарлага /төгрөг/
а/	Татварт	
1)	НӨАТатварт	9,047.275
2	ХАОАТ	2,708.890
3	Газарт	2,850.000
4	НДШ-д	6,863.598
5	ААНОАТ	335,890
	Нийт дүн:	21,805.653₮

Үйл ажиллагааны зардалд

5	Үйл ажиллагааны зардалд	34,128.298
6	Тээвэр шатахууны зардалд	6,891.897
7	Шуудан холбоо, бичиг хэрэгт	598,250
8	Цалин хөлс	34,566.999
9	Ашиглалтын зардалд	728,684
10	Ачаа тээврийн зардалд	1,927.850
11	Засварын зардалд	13,037.800

12	Бусад зардалд	8,582.203
13		
	Дүн:	100,461.981
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН:	122,267.634₮

2014 онд 6,620.422 төгрөгний ашигтай ажилласан байна. Орлогыг бүтцээр нь авч үзвэл 75 хувийг үйлчилгээний орлого, 25 хувийг буфетны орлого эзэлж байна. Зардлыг бүтцээр нь авч үзвэл 60 хувийг үйл ажиллагааны зардал, 40 хувийг бусад зардал эзэлж байна.

Жил бүр үйл ажиллагаагаа эхлүүлэхийн тулд Таван толгой транс ХХК-иас зээл авч гардаг. 2014 онд ТТТрансаас 24,859.100 төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл, 10,000.000 төгрөгний буцалтгүй тусламж авч “Жуулчин говь-1” “Жуулчин – Хонгор” баазуудын материаллаг баазыг 60%-тай шинэлчиллээ.

2011 оны хөрөнгө оруулалтын зээлнээс 43,000.000 төгрөг, 2014 оны хөрөнгө оруулалтын зээлнээс 19,859.100 төгрөг нийт хөрөнгө оруулалтын зээлийн үлдэгдэл 62,859.100 төгрөгийг төлж чадаагүй болно.

Манай компани үйл ажиллагаа явуулж байгаа хугацаандаа орон нутгийн иргэдийг аль болох олноор ажлын байраар хангах талаар арга хэмжээ авч үр бүтээлтэй ажилласаар ирсэн.

Мөн орон нутгаас зохиогдож байгаа үйл ажиллагаанд байнга идэвхтэй оролцсоор ирсэн. Үүнд.

1 Жил болгон уламжлал болж байгаа Сэврэй сумын ард иргэдээс 1 иргэнийг гадаад явах зардалд хандив болгон 800.000т

2. Хонгорын голд болдог Жуулчны баазуудын наадамд **1,600.000** төгрөгийн мөнгөн хандив, бусад аж ахуйн хандивуудыг хандивласан.

3. Ханхонгор сумын Мандах багийн овоо тахилганд **50.000т**

Нийт **2,450.000** төгрөгийн хандив орон нутагт хандивласан байна.

Мөн Жуулчин – Хонгор баазын хуучин хогийн цэгийг булуулж, Хонгорын голын 3 жуулчны баазуудтай / “Говь-эрдэнэ” , “Говь-Дисковер” “Говийн –Анар” / хамтран төвлөрсөн нэг хогийн цэгийг байгууллаа.

- Жуулчин Хонгор баазын ОО-ын асуудал маш хүндрэлтэй урьд хийсэн бохирын шингээлтийн хоолой байнга бөглөрч амрагчдаас гомдол их гардаг

91
 , бид гараар ухаж бөглөөг гаргадаг байсныг шинээр 100м газар бохирын шинэ хоолой ухаж шинээр бохирын холболт хийв. Урьд хийсэн бохирын системд тосны шүүр хийгдээгүй , гадагш гарсан шингээлтийн хоолой маш богино стандартад нийцэж хийгдээгүй байсан. Цаашид “Жуулчин Хонгор” баазын ресторан, 4 ханат гэрүүдийг шинэчлэх, гэрийн буйруудыг цементлэх, гэрийн тавилгуудыг шинэчлэх, гэрэлтүүлгийг сайжруулах, боловсон хүчний асуудал, мөн “Жуулчин –Хонгор” баазын газрын гэрчилгээ өнөөг хүртэл авагдаагүй зэрэг асуудлуудыг нэн яаралтай шийдвэрлэх,

- Жуулчин говь-1 баазын халуун усны зуухыг нам даралтын зуухаар сольсон. 2015 онд Жуулчин говь-1ын ОО душыг шинэчлэх ажлуудыг хийхээр төлөвлөж байна.
- Баазын Фургон машин шатахуун их иддэг, эвдрэл ихтэй байна. Хуучин машин болохоор нэг юмыг нь засахад нөгөө нь эвдэрдэг , 2014 онд мотор цохиж ээлж хийсэн. Энэ машины асуудлыг сүүлийн 2 жил ярьж байна.

Компани санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар , нийгмийн даатгал болон бусад татварын тооцоог цаг хугацаанд нь гаргаж , татвар , нийгмийн даатгалын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

2015 онд бид ,

- Жуулчин Говь-1 баазын ОО душийг нэн түрүүн шинэчлэх
- Жуулчин –Хонгор баазын ресторан, гэрүүдийг шинэчлэх
- Үйл ажиллагааны зардлыг багасгах, хэмнэх
- Жуулчин –Говь ХК-ийн website-ийг шинэчилж гадаад,дотоодын зах зээлд сурталчлан, жуулчдыг өөрийн сүлжээ байгууллагуудад хүлээн авч ашиг орлогоо нэмэгдүүлэх
- Мэргэжлийн боловсон хүчний асуудлыг шийдэх зэрэг зорилттой ажиллаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН



П. МӨНГӨНЦЭЦЭГ